

# “УМАРД СОЛОНГОСЫН ЦӨМИЙН ХӨТӨЛБӨР, ЦААШДЫН ХАНДЛАГА, НӨЛӨӨ”

Ж.Энхсайхан  
Элчин сайд,  
Профессор, Доктор (Ph.D)

**З**үүн хойд Азийн өнөөгийн байдал ба Солонгосын хойгийн асуудлаар үе үе бага хурал буюу дугуй ширээний ярилцлага зохиогддог ч олон улсын харилцааны байдал, өрнөлийн хандлага зэргээс болж байдал байнга өөрчлөгдөж байдаг. Тиймээс тэдгээрийг сайтар судалж улс төрийн нөхцөл байдал, аятай агшинг ашиглаж асуудлыг эвзүйгээр шийдвэрлэхэд эерэгээр нөлөөлөх боломжийг хайж байх хэрэгтэй юм. Бүс нутгийн бүх улс оронтой сайн харилцаатай, идэвхтэй гадаад бодлого явуулж байгаа Монгол Улс энэ асуудлаар ямар бодлого явуулж, тактикийн ямар оновчтой арга хэмжээ авах талаар ч санал бодлоо солилцох нь чухал болж байна.

Олон улсын эдийн засгийн харилцааны чухал хөдөлгүүр болж байгаа Зүүн Азид, нэн ялангуяа Зүүн хойд Азийн өрнүүн хөгжил, хамтын ажиллагаанд итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудал улс төрийн том саад тотгор болсоор байгааг хэн бүхэн мэднэ. Солонгосын хойгт “Хүйтэн дайн”-ы уур амьсгал даамжирсаар байгаагийн дээр Умард Солонгосын цөмийн хөтөлбөр хоёр Солонгосын харилцаанд саад хийж, Зүүн хойд Азид түгшүүртэй байдлыг даамжруулж, үе үе хурцатгасаар байна.

## Умард Солонгосын цөмийн хөтөлбөр

Түүхийг сөхвөл Умард Солонгос анх 1956 онд цөмийн хөтөлбөрөө боловсон хүчнээ бэлтгэхээс эхэлсэн байдаг. 1959 онд цөмийн салбарт хамтарч ажиллах тухай хэлэлцээрийг ЗХУ-тай байгуулж, 1962 онд Йонбьёнд Цөмийн судалгааны төв байгуулж, хоёр жилийн дараа 2 мегаватт хүчин чадал бүхий судалгааны реакторыг Зөвлөлтийн тусламжтайгаар барьж ашиглаж эхэлсэн байна. 1985 он гэхэд Умард Солонгос ЗХУ-ын туслалцаатайгаар 5 мегаватын хүчин чадалтай цөмийн реактор барьж, түүнд ашиглах цөмийн түлш үйлдвэрлэж, дараа нь ашигласан түлшнээсээ цөмийн зэвсэг үйлдвэрлэх нэг гол түүхий эд болох плутонийг салган авч цөмийн зэвсэг үйлдвэрлэх түүхий эдтэй болсон байна. 1970-1980-аад онд уран олборлодог болсон. 1974 онд ОУАЭА-ийн гишүүн болж, тус байгууллагаас техникийн туслалцаа авч боловсон хүчнээ давтан бэлддэг болсон юм.

Солонгосын дайны үед АНУ Умард Солонгосын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхээр нэг бус удаа далайлгаж байсан. АНУ 1958 онд Өмнөд Солонгосын нутаг дээр Honest John хэмээх цөмийн пуужин болон 280 мм-ийн цөмийн артиллерийг байрлуулж байсан байдаг. Тиймээс Умард Солонгос бараг 1950-иад оны сүүлчээс цөмийн зэвсэг үйлдвэрлэх санаа бодолтой болсон гэж үздэг байна. 1990-ээд оны эхээр Умард Солонгос нэгэнт үйлдвэрлэсэн байсан плутонио ашиглаж цөмийн зэвсэг хийхээр шийдвэрлэж тэрхүү түүхий эдийнхээ хэмжээгээ олон улсын хамтын нийгэмлэгээс, нэн ялангуяа ОУАЭА-аас нууж эхэлжээ. Гэтэл ОУАЭА-ийн шинжээчид Умард Солонгосын цөмийн үйл ажиллагаа болон хөтөлбөртэй танилцаж, үзлэг хийж байхдаа үйлдвэрлэсэн плутонийн хэмжээний талаар Солонгосын талын өгсөн мэдээлэлд эргэлзэж байгаагаа мэдэгдэж цөмийн хөтөлбөрийн нь 2 байгууламж болон ашигласан түлшийг хадгалж байгаа газарт очиж үзлэг хийх санал тавихад Солонгосын тал эсэргүүцсэнээр цөмийн хөтөлбөртэй нь холбогдсон хямрал эхэлжээ. Олон улсын хамтын нийгэмлэг Умард Солонгосыг “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ” болон ОУАЭА-ийн Дүрмийн дагуу авсан үүргээ хэрэгжүүлж байгаад эргэлзэх болсон тул Умард Солонгос 1994 онд ОУАЭА-ийн гишүүнчлэлээс, 2003 онд Үл дэлгэрүүлэх гэрээнээс тус тус гарсан үйлдлээрээ цөмийн зэвсэгтэй болох бодолтой байгаагаа нотолсон бөгөөд түүнийгээ нууж далдлахаа больж, харин ч цөмийн туршилт хийж, цөмийн зэвсэгтэй болохоо яриа хэлэлцээндээ хөшүүрэг болгож ашигладаг болсон. Мөн цөмийн зэвсэг үйлдвэрлэхэд шаардлагатай хоёр дахь түүхий эд болох нэн өндөр хэмжээнд баяжуулсан уран гаргадаг болоод байна.

Цөмийн зэвсэг гэдэгт цөмийн цэнэг толгойноос гадна түүнийг тээвэрлэх техник хэрэгсэл багтдаг. Түүнд бөмбөг, артиллерийн сум, нисэх болон шумбагч онгоц, төрөл бүрийн ангиллын пуужин багтдаг. Мөн довтолгооноос хамгаалахын тулд цөмийн газрын болон далайн мина ч багтдаг. Умард Солонгос 1970-аад оноос ЗХУ-аас ойрын тусгалын пуужин авч түүнийг үйлдвэрлэх технологийг эзэмшиж бага болон дунд тусгалын пуужин хийж, зарим улсад гаргадаг болсон. Судлаачдыг үзэж байгаагаар Умард Солонгос одоо 1000 гаруй пуужинтай болоод байна. Одоо алсын тусгалтай стратегийн пуужин хийж туршиж байгаа ажээ.

### **Цөмийн зэвсэгтэй болох зорилго, аюулгүй байдлаа “хамгаалах” үзэл баримтлал**

Цөмийн зэвсэгтэй улсууд тийм зэвсэгтэй байх шаардлага байгаагаа ард иргэддээ болон олон улсын хамтын нийгэмлэгт тайлбарлах хэрэгтэй байдаг. Тэдний

адил Умард Солонгос ч мөн тийм зэвсэгтэй болж байгаагаа тайлбарлахыг оролддог. Тухайлбал, төрийн социалист тогтолцоогоо АНУ-ын өдөөн хатгалга, довтолгоо, дайсагнасан бодлогоос хамгаалах, тийм санаархлыг нь цөмийн зэвсгээрээ тогтоон барих, мөн тийм зэвсэгтэй байгаагийнхаа үр нөлөөгөөр Солонгосын хойгт болон Зүүн хойд Азид тогтвортой байдлыг хангаж бэхжүүлэхэд дөхөм үзүүлнэ гэж тайлбарладаг. Мөн цөмийн зэвсэг нь хуваагдмал байгаа Солонгосын хойгийг Умард Солонгосын тавьж байгаа нөхцөл, саналын үндсэн дээр нэгтгэхэд эерэг нөлөө үзүүлэх учиртай гэж мөн тайлбарладаг. Нэгэнт цөмийн зэвсэгтэй болсны дараа батлан хамгаалах зардлынхаа хэмжээг бууруулж хэмнэсэн хөрөнгийг нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх, ард иргэдийнхээ аж амьдралыг сайжруулахад зарцуулах боломжтой болох ажээ. Эдгээр бүх тайлбараа үндэслэн Умард Солонгос цөмийн зэвсэгтэй бусад улсын адил “цөмийн тогтоон барих (Nuclear deterrence)” номлолтой болсноо зарлаж, 2012 онд Үндсэн хуулийнхаа оршил хэсэгт улс орноо “Цөмийн зэвсэгтэй улс” хэмээн тунхагласан заалтыг нэмж оруулсан байна. 2013 онд “Өөрийгөө хамгаалах цөмийн зэвсэгтэй статусаа бэхжүүлэх тухай”, “Сансрын огторгуйг хөгжүүлэх тухай” хуулийг тус тус баталж, Сансрыг хөгжүүлэх төрийн товчоо байгуулсан. Мөн 2013 онд Цөмийн энергийн Ерөнхий товчооны эрх мэдлийг үлэмж хэмжээгээр өргөтгөж, Цөмийн энергийн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн яам болгосон.

Умард Солонгос өнөөг хүртэл цөмийн хөтөлбөртөө онцгой анхаарал тавьж ирсэн бөгөөд цаашид ч энэ бодлогоо үргэлжлүүлэх хандлагатай байна. Тухайлбал, цөмийн цэнэг толгойн жин, оворыг бага болгож (Miniaturize) пуужин дээр байрлуулах, цөмийн зэвсгийн хөнөөх хүч чадлыг багасгах замаар тухайн улс төр, цэргийн байдалд тохируулан хэрэглэх бодит боломжтой болох, тээгч хэрэгслийг (өөрөөр хэлбэл пуужинг) төрөлжүүлэх, илүү мэргэн тусгалтай болгох, тив алгасагч пуужинг агаар мандлаас гарах болон эргэж орох техникийн боломжтой болгох гэх мэт арга хэмжээг авч байна. Чингэх нь зарлаад байгаа “цөмийн тогтоон барих” номлолоо бодит агуулгаар баяжуулан бэхжүүлэхийн дээр АНУ болон цөмийн зэвсэгтэй бусад улс орон, тэдний холбоотнуудтай улс төрийн асуудлаар яриа хэлэлцээ хийхэд чухал хөшүүрэг болгон ашиглаж байна. Тиймээс түүний цөмийн зэвсгийн хөтөлбөрийн талаар хийгдэж байсан Зургаан талт хэлэлцээнд ч тэрхүү байдлаа ашиглаж, өөрийн байр суурийг тулгаж ирсэн байдаг. Иймд Зургаан талт хэлэлцээг аль болохоор хойшлуулах буюу хэлэлцээг сунжруулах бодолтой байдаг.

Нөгөөтэйгүүр, Умард Солонгос “цөмийн тогтоон барих” бодлогоо улам лавшруулах үүднээс цөмийн цохилтонд эхлээд өртөх тохиолдолд цөмийн хариу цохилт өгөх боломжтой болоход анхаарч байна. Тухайлбал, зарим

төрлийн цөмийн пуужинг хөдөлгөөнт сууринд байрлуулж, байршлыг нь байнга өөрчилж, шууд цохилтоос хамгаалах, цөмийн зарим пуужинг шумбагч онгоцонд байрлуулж далайн гүнд байнга барьж байх талаар тодорхой арга хэмжээ авч байна.

### Зургаан талт хэлэлцээ

Умард Солонгос 2003 онд Үл дэлгэрүүлэх гэрээнээс гарсан тул түүний цөмийн зэвсгийн хөтөлбөрийг зогсоох нөхцөл болзлын талаар ярилцах механизм болгож эхлээд 3 талт (АНУ, Умард Солонгос болон БНАХУ-ын хоорондын) хэлэлцээг хийлгэж байснаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд нөлөө үзүүлж болох Өмнөд Солонгос, ОХУ болон Японыг татан оруулснаар Зургаан талт хэлэлцээ эхэлсэн байдаг. Тэрхүү хэлэлцээний гол зорилго бол яриа хэлэлцээ хийх замаар Умард Солонгосыг цөмийн зэвсгийн хөтөлбөрөөс нь татгалзуулах нөхцөл болзлын талаар ярилцаж тохирох явдал байв. Чингэхийн тулд түүнд гаргаж өгч болох аюулгүй байдлын баталгааны агуулга хэлбэр, Умард Солонгосыг хүлээн зөвшөөрч харилцааг хэвийн болгох нөхцөл болзол, эрчим хүчний чиглэлээр түүнд үзүүлж болох тусламж дэмжлэг зэрэг асуудлаар ярилцаж нэгдсэн шийдвэрт хүрэх явдал байв. 2003-2008 онд Зургаан талт хэлэлцээг удаа дараа хийж зарим тохиролцоонд хүрч байсан боловч талуудын, нэн ялангуяа Умард Солонгос болон АНУ-ын бие биедээ үл итгэх хандлага, мөн тохирсон зүйлсээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлсөн тухайн үеийн улс төрийн байдал, үйл явдлаас болж ахиц гарахгүй байв. Тухайлбал, 2005 оны 9 дүгээр сард талууд асуудлыг эвзүйгээр хэрхэн зохицуулах талаар тохирч байсан боловч удалгүй Умард Солонгос пуужингийн туршилт хийсний улмаас НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн даргаас түүнийг нь буруушаасан мэдэгдэл хийв. Түүнийг нь Умард Солонгос эсэргүүцэж Зургаан талт хэлэлцээнд оролцохгүй бөгөөд түр зогсоогоод байсан ураныг өндөр хэмжээнд баяжуулах ажлаа сэргээхээ мэдэгдсэн. Тиймээс ч Зургаан талт хэлэлцээ 2008 оноос мухардмал байдалд байсаар ирлээ. АНУ болон Өмнөд Солонгос цөмийн зэвсгийн хөтөлбөрийн асуудлаар Умард Солонгостой хоёр талын уулзалтыг үе үе албан бусаар уулзаж, Зургаан талт хэлэлцээг сэргэх боломжийг хайсаар ирлээ.

Умард Солонгос Зургаан талт хэлэлцээний форматыг өөрт нь ашиггүй гэж үздэг бөгөөд гол хэлэлцээг шууд АНУ-тай хийх бодлого баримталж ирсэн, чингэхийг ч удаа дараа шаардаж байдаг. Нөгөөтэйгүүр АНУ өөрийн холбоотон болох Өмнөд Солонгос болон Японтой тохирсныхоо дагуу БНАСАУ-тай өндөр хэмжээнд шууд хэлэлцээ хийхээс зайлсхийж ирсэн. Хэдий тийм боловч АНУ хоёр холбоотонтойгоо тохирсны дагуу Умард Солонгостой нэг бус удаа дунд

зиндааны албан бус уулзалтыг хийж, Зургаан талт хэлэлцээг сэргээх нөхцөл боломжийн талаар санал солилцож ирэв.

Хоёр талын уулзалтын үеэр Умард Солонгос Зургаан талт хэлэлцээг ямар ч урьдчилсан нөхцөл болзолгүйгээр эхлүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлж байсан бол АНУ Умард Солонгосыг давын өмнө цөмийн хөтөлбөрийн талаар хоёр талаар, мөн Зургаан талын хэлэлцээний явцад тохирсноо хэрэгжүүлэх буюу тэгэх чиглэлд тодорхой алхам хийхийг шаардсаар байна.

## Сүүлийн үеийн шинэлэг хандлага

Олон улсын байдал нэг хэвийн байдаггүй тул гарч буй өөрчлөлтийг улс орнууд нарийн ажиг бодлогоо тохируулж зохицуулдаг билээ. Умард Солонгосын цөмийн хөтөлбөртэй холбогдолтой дараах хандлага гарч байна. Үүнд:

1. 2016 оны 1 дүгээр сард БНАСАУ-ын тал Умард Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөрөө зогсоож, улмаар хоёр улсын хоорондын дайны байдлыг эцэс болгохыг санал болгосон байна. АНУ хариу өгч амжаагүй байхад Умард Солонгос цөмийн зэвсгээ туршснаар асуудал мухардмал байдалд орсон байна. 2 дугаар сард Умард Солонгосын болон АНУ-ын дипломатууд Берлин хотноо албан бусаар уулзсан байна. Тэр үеэр Умард Солонгосын тал дайсагнасан байдлыг эцэс болгох зорилгоор яриа хэлэлцээг эхлүүлэхийг санал болгосон байна. Чингэхдээ Солонгосын тал цөмийн зэвсгийнхээ туршилтыг 1 жилийн хугацаанд хийхээ азнаж, хариуд нь АНУ Өмнөд Солонгостой хамтран жил бүр хийдэг цэргийн хээрийн сургуулилтыг мөн энэ жил хийхгүй байхыг санал болгожээ. Гэвч АНУ энхтайвны гэрээ байгуулах асуудал нь яваандаа АНУ-ыг Өмнөд Солонгос, Японоос цэргээ барьж байх шалтгаангүй болгож болзошгүй гэж үзсэн учраас саналыг дэмжиж чадахгүй гэсэн хариу өгсөн байна. АНУ-ын тэрхүү хариуг Америкийн зарим мэргэжилтэн, судлаачид буруушааж, Умард Солонгосын саналыг хүлээн авч яриа хэлэлцээг эхлүүлж, хэлэлцээ явагдах тэр хугацаанд цөмийн зэвсгийн болон пуужингийн туршилт хийхгүй байхыг санал болгох хэрэгтэй байсан гэж үзэж шүүмжлэнгүй хандсан. Тэдний үзэж байгаагаар энхтайвны гэрээг тийм амархан байгуулахгүй тул цаг хугацааг Умард Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөрийг тодорхой хугацаагаар “царцаах” боломжтой байх байсан ажээ. Тэр хугацаанд Умард Солонгосын эсрэг авсан олон улсын хориг арга хэмжээ байр сууриа уян хатан болгоход нь зохих ёсоор нөлөөлөх учиртай байв. Эдгээрээс үзвэл хоёр тал яриа хэлэлцээг сэргээх сонирхолтой байгаа нь харагдаж байна.

2. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажиллагаа ид явагдаж байгаа тул АНУ-аас Умард Солонгостой харилцах бодлогод 2017 оны хавар хүртэл зарчмын ямар нэгэн өөрчлөлт гарахгүй (хэрэв Умард Солонгосын талаас илт өдөөн хатгасан арга хэмжээ авахгүй бол). Сүүлийн үед Обамагийн засаг захиргааг Умард Солонгосын талаар явуулж ирсэн “туйлын тэвчээртэй байх” (Strategic patience) бодлогыг Умард Солонгост цөмийн зэвсгээ хөгжүүлэх боломж олгож байна гэж шүүмжлэх явдал АНУ-д газар авсаар байна. Тиймээс сонгуульд хэн ялахаас эс хамаарч бодлогод өөрчлөлт гарах болов уу.
3. Энэ 5 дугаар сард Солонгосын Хөдөлмөрийн Намын VII их хурал болж, Ким Жон Ун намын дарга болж байр сууриа бэхжүүлж, өөрийн талын хүмүүсийг нам, төрийн чухал албан тушаалд тавьж чадсан. Тухайлбал, Ким Жон Уны дотны хүн болох Ри Су Йонг (Ri Su Yong) 2014 онд Гадаад харилцааны сайдаар томилогдон ажиллаж байгаад СХН-ын их хурлаас УТТ-ны гишүүн, намын Төв Хорооны орлогч даргаар томилогдов. Түүний оронд Гадаад харилцааны орлогч сайд бөгөөд Зургаан талт хэлэлцээнд Умард Солонгосыг төлөөлж байсан Ри Йонг Хо (Ri Yong Ho) СХН-ын УТТ-ны орлогч гишүүн, НТХ-ны жинхэнэ гишүүн бөгөөд Гадаад харилцааны сайдаар томилогдоод байна.
4. СХН-ын их хурлаас Умард Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөрийн талаар гаргасан шийдвэрт эдийн засаг болон цөмийн зэвсгээ нэгэн зэрэг хөгжүүлэх *pyongjin* бодлогоо тууштай үргэлжлүүлэх, цөмийн зэвсгээ тоо, чанарын хувьд ахиулах талаар заасны дээр өөрийн нь эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхээр завдахаас бусад тохиолдолд цөмийн зэвсгээ түрүүлж хэрэглэхгүй, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй, цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцийг буй болгоход дөхөм үзүүлнэ гэж заасан байна. Нөгөөтэйгүүр цөмийн зэвсгээсээ дараах нөхцөлд татгалзах бодлогоо үргэлжлүүлэн баримтлах ажээ:
  - a. АНУ-аас Умард Солонгосын эсрэг явуулж буй дайсагнасан бодлогоосоо татгалзах (өөрөөр хэлбэл АНУ Өмнөд Солонгосоос цэргээ бүрэн гаргаж, түүний эсрэг авсан эдийн засгийн бүх хориг арга хэмжээнээсээ татгалзаж, хоёр талын харилцааг хэвийн болгох)
  - b. Дэлхий дахинаа цөмийн зэвсгийг бүрэн устгах. Энэ бүхнээс үзвэл Умард Солонгос цөмийн зэвсгээсээ сайн дураараа татгалзахгүй нь тодорхой байна.
5. АНУ, Европын Холбоо, цаашилбал Хятад, ОХУ Умард Солонгосын эсрэг авсан эдийн зэвсгийн хориг арга хэмжээгээ улам чангатгаж байна.

Дээр дурдсан бүхнээс үзвэл Умард Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөрийн асуудал цаашид дараах 3 чиглэлээр өрнөж болох юм гэж үзэж байна. Үүнд:

- a. Аль аль талаасаа өнөөг хүртэл баримталж ирсэн бодлого онцын өөрчлөлтгүйгээр үргэлжилнэ. Чингэх нь Умард Солонгост ашигтай.
- b. Умард Солонгосын эсрэг авч буй хориг арга хэмжээ тус улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж дотоод байдал нь 1-2 жилээс хүндэрч улмаар цөмийн хөтөлбөрийн талаар баримталж буй бодлого нь уян хатан болж арга буюу яриа хэлэлцээ хийхэд хүрнэ.
- c. Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудалд нааштай ахиц гарахгүй, харин ч цөмийн зэвсгийн тоо, чанар ахиц гарах нь Өмнөд Солонгос болон Японд өөрсдөө цөмийн зэвсэгтэй болох яриа, хөдөлгөөн газар авч, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэм суларч ганхахад хүрвэл АНУ ямарваа нэгэн аргаар хүч хэрэглэхийг завдана.

Дээрх 3 сценарийн алийг Ким Жон Ун дагахыг одоогоор хэлэхэд эрт байна. Өөрийн байр суурийг дотооддоо бэхжүүлсэн нь түүнд шийдэмгий шийдвэр гаргах боломжийг олгож байна. Нөгөөтэйгүүр олон улсын хориг арга хэмжээ эдийн засагт нь, цаашилбал түүний байр сууринд сөргөөр нөлөөлж болох тул тэрээр 2 дахь хувилбарыг сонгох болов уу гэж үзэж байна.